



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар-Дархан чиглэлийн автозамын өргөтгөлийн трасст орсон IV хэсгийн ПК3+900-ПК4+900 хооронд Дарханы ДЦС-ийн тунгаасан усны шугам, ПК0+500-ПК0+600 хоорондох борооны ус зайлуулах шугамын ажлын хүрээнд бий болсон 3 нэрийн, нийт 620,636,750.00 (зургаан зуун хорин сая зургаан зуун гучин зургаан мянга долоон зуун тавин) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд (капиталжуулан) бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Жаргалсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001409

бодлого, зохицуулалтын
дугаар сарын ...-Ны
... дугаар тогтоолын х...

"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Марк, хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)
1	Шуудуу ухаж бэлтгэх, булах ажил	2021	950м урт, 2м өргөн, 1.75 м гүнтэй шуудуу	м	950	197,634.18	187,752,473.00
2	Ган хоолойг зэврэлтээс хамгаалах түрхлэг	2021	Ф=426мм ган хоолой, 1899.5 м урт	м	1899.5	8,423.27	16,000,000.00
3	Тунгаасан ус дамжуулах шугам	2021	Ф=426мм ган хоолой	м	1899.5	219,470.53	416,884,277.00
Нийт дүн							620,636,750.00
							(зургаан зуун хорин сая зургаан зуун гучин зургаан мянга долоон зуун тавин төгрөг)